

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНД, ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

/2020 оны 4 сарын байдлаар/

№	Үзүүлэлт	БОЭТ	Сумдын эмнэлэг	Өрхийн эмнэлэг	Хувийн эмнэлэг	Цэргийн анги	Нийт дүн
1	Нийт үзлэг	34352	37548	21361	13403	2319	108983
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	10442	10253	3150	1051	2122	27018
3	Идэвхтэй хяналтын үзлэг	3571	7592	7588	1788	1	20520
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	10790	8499	4880	3474	129	27772
5	Нийт төрөлт	443	111				554
6	Хэвтэн эмчлүүлэгчид	2519	1994		982	13	5508
7	Нас баралт	15	47	33			95

- Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нийт 108983 хүнд үзлэг шинжилгээ хийсний 43.6%-д нь урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хяналт тандалтын үзлэг хийгдсэн байна.
- Ортой эмнэлгүүдэд нийт 5508 хүнийг 34670 ор хоногоор хэвтүүлэн эмчилсэн нь нэг хүн дунджаар 6.2 хоног хэвтэн эмчлүүлсэн байна.
- 4 сарын байдлаар 27772 халдварт бус өвчлөл шинээр бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 104 тохиолдлоор өссөн байна.
- 4 сарын байдлаар 429 хүн осол гэмтэлд өртсөний улмаас тусламж авсан ба осол гэмтлээр 14 хүн нас барж өнгөрсөн оноос 2-р, өвчлөл 29 тохиолдлоор өссөн байна. Осол гэмтлээр нас барагсдын
 - 7,1%/1 /нь амиа хорлосон /Мн-1/
 - 7,1%/1/ нь бусдад хорлогдож /Бу/
 - 46,1% /6 /нь зам тээврийн осол-Гт-1,Нн-1,Эу-1,БОЭТ-3
 - 46,1%/6/нь бусад ослоор/Бд-1, Бу-1, Гт-2 Хү-1,Шб-1/ тус тус эндсэн байна.

Осол гэмтлээр нас барагсад нь 76,9%/10/ эрэгтэй хүмүүс эндсэн ба 3 нь эмнэлэгт хүргэгдсэн боловч хоног болоогүй нас баралт 2 /66,6%/ байна. Бусад тохиолдлууд эмнэлгийн ямар нэг тусламж авч чадаагүй газар дээрээ нас барсан байна.

- Оны гарсаар 95 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 14.7 % нь осол гэмтлээр, 20% нь хорт хавдраар, 7.3% нь зүрхний шигдээс, тархинд цус харвалт зэрэг сэргийлж болох эндэгдэлээр, 3.1% нь нярай үеийн эмгэгийн улмаас нас барсан байна.
- Нялхсын эндэгдлийн 7 /Гт-1,Но-1,Хү-1,Цц-1,БОЭТ-3 / тохиолдол бүртгэгдсэн нь 1000 амьд төрөлтөд 12,5% байна. Нялхсын эндэгдлийн шалтгааны 42.8% /3/ нярайн эмгэг, 1 хатгаа, 1 тархинд цус харвалт, 2 осол гэмтэлээр эндсэн байна.
- Түргэн тусламжийн 4930 дуудлагад явж үйлчилсний 668/13,5%/ нь алсын дуудлага, 177 /3.5%/ нь осол гэмтлийн яаралтай дуудлага байсан байна. Нийт дуудлагын 80.2% -д 0-20 минутны дотор гарч үйлчилсэн байна .
- 4 сарын байдлаар 4962 хүүхдийг идэвхтэй хянаж, хооллолт өсөлт хөгжилтийн байдлыг үнэлэн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн нь хяналтад хамрагдвал зохих хүүхдийн 59.3% эзэлж байгаа нь хангалтгүй байна. Хяналтанд хамрагдсан хүүхдүүдээс 17 хүүхэд жингийн алдагдалтай байгаа нь нийт хүүхдийн 0,2%-г эзэлж байна.
- Нийт 554 эх төрж 557 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 45 төрөлтөөр хүн амын төрөлт өссөн байна. Нийт төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа 1,1:1 байгаа ба эрэгтэй хүйс давамгайлж байна. Нийт төрөлтийн 36/6,5%/ охидын төрөлт эзэлж байгаа нь анхаарал татаж байгаа үзүүлэлт байна./Бу-1,Гт-4,Мн-5,Но-2,Сэ-1,Хб-3,Хх-1,Хү-1,Цо-3, Цц-3,Шб-4,Өо-2, Эх-5,Бг-1/.
- 4 сарын байдлаар 190 эх үр хөндүүлж 1000 амьд төрөлтөд 341.1 байгаа нь өнгөрсөн оноос 14.5-р өссөн үзүүлэлт байна.Өсвөр насны охидын үр хөндөлт-14 /7,3% /Мо-2,Нн-1,Хб-1,Цц-2,Шб-7,Өо-1/ байна.

11. Он гараад 245 халдварт өвчин бүртгэж эмчилсэн нь өнгөрсөн оноос 110 тохиолдлоор өссөн байна. Нийт халдварт өвчний 33.8%-г салхинцэцэг, 2,4%-г гар хөл амны өвчин, 56.7%-г БЗДХ өвчин тус тус эзэлж байна.
12. Нийт эмийн сангууд 31159 жор хүлээн авч, 3096388.4 сая төгрөгний эм бараа борлуулалт хийсэн байна.
13. ЭЭСангуудад нийт 6850 жор ирсний 48.6% /3332/ нь ЭМДаатгалын, 2,5%/172/ мансууруулах сэтгэц нөлөөт эмийн, 48.8% /3346/ нь энгийн эмийн жор байсан байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт дундажаар 80.8 % байна.
14. БОЭТөвд 15 эндэгдэл тохиолдож 13 задлан шинжилгээнд хамруулсан ба задлан шинжилгээний хувь 86.6% тай байна. Үндсэн оношийн зөрөө 4.

Анхаарал татсан үзүүлэлтүүд ба цаашид анхаарах асуудал:

Үзүүлэлт	хэмжих нэгж	2019.4 он	2020.4 он	өөрчлөлт
Нялхасын эндэгдэл	1000 амьд төрөлтөд	11.8	12.5	0.7
Үр хөндөлт	1000 амьд төрөлтөд	385.8	341.1	-44.7
Үүнээс охидын	хувь	5.1	7.3	2.2
Хурц халдварт өвчин	10000 хүн амд	19.8	35	15.2
БЗДХ	10000 хүн амд	9.9	19.8	9.9
Үүнээс: Тэмбүү	тоо	36	43	7
Заг хүйтэн	тоо	20	31	11
Трихоминиаз	тоо	12	36	24
Үүнээс өсвөр үе	хувь	8/11.7	13/ 9,2	-2.5
Хүүхдийн хяналт /0-1 нас/	хувь	84	72	-12
Хүүхдийн хяналт /1-5 нас/	хувь	43	33	-10

1. Ковид 19-тэй холбоотой авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн дүнд эмнэлгээр үйлчлүүлэгчдийн тоо 11,6 хувиар, урьдчилан сэргийлэх үзлэг 32,3 хувиар буурч эмнэлгүүдийн ачаалал харьцангуй буурсан байна. Энэ нөхцөлд хүүхдийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, ахмад настан, жирэмсэн эхчүүдийн, гэрийн эргэлтийн, эрт илрүүлгийн гэх мэт бусад үйлчилгээг зөв зохион байгуулж эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй чанартай явуулах.
2. Үр хөндөлт 1000 амьд төрөлтөд 44.7-р, үүнээс охидын үр хөндөлт 2.2-р тус тус нэмэгдсэн байна. Хүсээгүй жирэмслэлтийг бууруулах арга хэмжээ / нөхөн үржихүйн насны судалгааг нарийвчлан гаргаж, зорилтод бүлэгт чиглэсэн ЖСА хэрэглээг сайжруулах, МСС, өсвөр үеийн кабенитын үйл ажиллагаа/ авч хэрэгжүүлэх.
3. БЗДХ-н 17.8% нь жирэмсний үзлэгээс, 44.2% нь урьдчилан сэргийлэх үзлэгээр, 47.1% нь өвчний учир амбулатороор, 7.8% нь тандалтын үзлэгээс илэрсэн байна. БЗДХ-н тандалтын үзлэгийг сайжруулах, хавьталуудыг эрт илрүүлж эмчилэхэд анхаарах шаардлагатай ба дээрх үзүүлэлтээс харахад БЗДХ-н тархалт үүнээс ч өндөр байх магадлалтай байна.
4. 0-1 насны хүүхдийн хяналт 12-р, 1-5 хүртэлх насны хүүхдийн хяналт 10-р тус тус буурсан ба тураалтай хүүхэд 17 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 8 тохиолдлоор нэмэгдсэн байгаа нь хяналтын хувь нэмэгдэхэд тураалын тархалт нэмэгдэх хандлагатайг харуулж байна. Хүүхдийн хяналт, түүний чанарт илүү анхаарах.
5. 2019 оны мөн үед нялхсын эндэгдэлийн 75% нь эрт нярайн эндэгдэл байсан бол 2020 онд 42.8% нь эрт нярайн, 57.1% нь сараас дээш насны хүүхэд байгаа ба хатгаа, осол гэмтэл, тархинд цус харвалт зэрэг шалтгаанаар эндсэн нь хүүхдийн хяналт, асаргаа сувилгаа, хараа хяналтыг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Мэдээлэл бэлтгэсэн: ЭМГ-н статистикч Б Мидэрсүрэн , Д. Гантогтох